



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/20

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Тахь адууг Монголд нутагшуулсаны 30 жилийн ойн нэрэмжит Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг - Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Э.Саранцэцэг - Жаргалант сум Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б.Отгонцэцэг - Төрийн бус байгууллагын төлөөлөл

П.Ган-Эрдэнэ - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Эрдэнэцэцэг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02.0162
D/Tush-A/20-Be